БАТЛАВ.

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН

ДАРГА С.ЦЭДЭНСОДНОМ

# БАРИЛГА, ГАДНА ФАСАДНЫ ЗАСВАР /ХАН-УУЛ ДҮҮРЭГ, 4 ДҮГЭЭР ХОРОО, 34 ДҮГЭЭР СУРГУУЛЬ/-ЫН ЗУРАГ, ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2024 оны 02-р сарын 21-ны өдөр № 2024/21 Улаанбаатар хот

| | | |
|---|---|---|
| 1. | Зураг төсөл боловсруулах үндэслэл | Нийслэлийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн А/824 дүгээр захирамж |
| 2. | Байршил, эдэлбэр газрын хэмжээ | - Хан-Уул дүүргийн 34 дүгээр сургууль |
| 3. | Зориулалт, хүчин чадал | - Сургуулийн гадна фасад, хичээлийн байрны үүдний гонх шинэчлэх, дээврийн ус зайлуулах хоолой шинэчлэх |
| 4. | Төсөл гүйцэтгэх хугацаа | - Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно |
| 5. | Барилгын үндсэн бүтээц, материал | - Төслөөр. |
| 6. | Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага | - Техникийн нөхцөл шаардлагатай бол ачаалал тооцож хангагч байгууллагуудаас шинээр техникийн нөхцөлүүдийг гаргуулна. Тус техникийн нөхцөлийн хүрээнд гадна инженерийн шугам, сүлжээний зураг, төсөв боловсруулах, техникийн нөхцөл олгогдохгүй тохиолдолд өөрийн эх үүсвэрээр инженерийн шугам, сүлжээний зураг, төсөв боловсруулан холбогдох байгууллагуудтай зөвшилцөн, батлуулах. |
| 7. | Зураг төслийн иж бүрдэл | Баримт бичгийн иж бүрдэл:<br>- Одоогийн байдлын фото зураг<br>- Ашиглагч байгууллагатай ажлын тоо, хэмжээ зөвшилцсөн хурлын тэмдэглэл.<br>- Мэргэжлийн хяналт болон Онцгой байдлын дүгнэлт /шаардлагатай тохиолдолд/<br>- Магадлалын дүгнэлт /хавсралтын хамт/;<br>Ажлын зургийн иж бүрдэл:<br>- Хэмжилтийн, өөрчлөлтийн ажлын зураг;<br>- Өрөө тохижуулах рендер зураг;<br>- Гадна инженерийн шугам сүлжээ /шаардлагатай тохиолдолд/;<br>- Барилгын нэгдсэн төсөв /Тооцооны ESTIMATOR-PRO программ/; |
| 8. | Төсөл боловсруулах үе шат | Ажлын зураг төсөв нэг үе шаттай:<br>- Ажлын зураг, төсөв боловсруулж, батлуулах; |
| 9. | Төсөл боловсруулах байгууллага | - Барилга хот байгуулалтын сайдын тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам”-ын Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий хуулийн этгээд; |
| 10. | Төслийн захиалагч | - Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар; |
| 11. | Засвар хийгдэх ажлууд | - Сургуулийн барилгын дулаан алдагдалын тооцоо гаргаж гадна фасадыг дулаан алдагдалгүй байхаар дулаалж, шинэчлэх.<br>- Хичээлийн байрны үүдний гонх шинэчлэх.<br>- Дээврийн ус зайлуулах хоолой шинэчлэх. |

| | | |
|---|---|---|
| | | - Дээрх ажлуудыг хийхэд дагалдан гарах шаардлагатай засварын ажлуудыг хийх. |
| 12. | Онцгой нөхцөл | Засварын ажилд тавигдах шаардлага:<br>- Засварын ажилд ашиглах материалыг сонгохдоо орчин үеийн дэвшилтэд технологи нэвтрүүлсэн шинэ, стандарын шаардлага хангасан, чанартай материалаар хийх;<br>- Дулаалгын материал нь гарал үүслийн болон тохирлын гэрчилгээтэй, лабораторийн дүгнэлттэй байна. Дулаалгын материалын төрөл, зузаан, бусад үзүүлэлтийг сонгохдоо дулаан техникийн тооцоог үндэслэн сонгох.<br>- Дулаалгын болон фасадны материал нь гал дэмждэггүй байхаар төлөвлөх.<br>- Даацын бүтээцэд өөрчлөлт орсон тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаар дүгнэлт гаргуулж, ажлын зураг зурах;<br>- Тендерт ирүүлэх төсвийг зохиохдоо заавал ажлын талбарт очиж, хэмжилт хийн фото зургаар баталгаажуулах.<br>- Ажлыг гүйцэтгэхдээ батлагдсан төсөвт өртөгт багтах хэмжээгээр ажлын зураг, төсвийг боловсруулах. |
| 13. | Ерөнхий төлөвлөгөө, Зураг төсөл боловсруулахад ашиглах материал | Төсөл, хөтөлбөрүүд:<br>- Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага;<br>Хууль тогтоомжууд:<br>- Барилгын тухай хууль;<br>Норм, нормативууд:<br>- Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт /БНбД 31-25-22/<br>- Барилгын гадна ханын шаардлагатай дулаан тусгаарлалтын ажлын техникийн дүрэм /БД 12-103-07/<br>- Барилгын дулаан хамгаалалт /БНБД 23-02-09/<br>- Ашиглаж байгаа барилгад дулаалгын систем хийж гүйцэтгэх технологийн заавар /БД 23-101-03/<br>- Заслын ажил /БНбД 31-10-05/<br>- Барилгын бүтээц, ажлын төрлөөр төсвийн суурь норм, түүний хавсралтуудыг боловсруулах хэрэглэх дүрэм /БНбД 81-10-02/<br>- Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм /БНбД 81-94-12/<br>- Барилгын төсөв зохион дүрэм /БНбД 81-95-12/<br>- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм<br>- Бусад холбогдох норм, дүрэм<br>Стандартууд:<br>- “Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал ерөнхий шаардлага” MNS 6782:2019<br>- “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага” MNS 4990:2000<br>- “Ажлын байрны хүчдэлийн түвшин” MNS 12.097-91, MNS 12.098-91, MNS 12.101-091<br>- Бусад холбогдох стандартууд; |

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ЗТХ-ИЙН ДАРГА ...................... /Б.ЛХАГВАЖАВ/

БОЛОВСРУУЛСАН:
НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ЗТХ-ИЙН ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР ...................... /Б.БАТ-ОРГИЛ/